

245



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 26

№340

Улаанбаатар хот

Улсын Үйлвэрийн газар
байгуулах тухай.

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн
Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу
"Цамбагарав" рестораныг улсын үйлвэрийн газар болгон
зохион байгуулсугай.

2. "Цамбагарав" ресторан /УҮГ/-ны цүрмийг хавсралт
ёсоор баталжсугай.

3. Энэ тогтоол гарч байгаатай холбогдуулан Улаанбаатар
хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 299 дүгээр
тогтоолын I дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тус рестораныг 1992 оны I улиралд бартаан хувьчлахыг
Хотын Өмч хувьчлалын комисс /н.Ганжуяг/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Signature]
Л.ЭНЭЭШИ

[Signature]

Ц.БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 370 тоот тогтоолын хавсралт

Цамбагараа зоогийн газрын /УУГ/ дүрэм

Бэг. Цайтлаг үнцэслэл

- 1.1 Цамбагараа зоогийн газар нь /цаашид зоогийн газар/ бие даан үйлдвэрлэл үйлчилгээ явуулах улсын үйлдвэрийн газар юм.
- 1.2 Цамбагараа зоогийн газар нь Улаанбаатар хотын Өнөр хорооллын үйлчилгээний II төвд байрлаж, олон нэр төрлийн хоол, зууш, нарийн боовоор хүн амд үйлчилж, тэдний чөлөөт цагийг нэмэгдүүлж, тав тухтай заруулахад оршино.
- 1.3 Зоогийн газар нь өөртөө мэдэн бичгийн хөвдөмөл хуудас, тэмдэг хэрэглэн, бэлтгэн захицах дахтай байна.
- 1.4 Зоогийн газар нь хөдөлмөрийн дотоод журмын бөлсөөр зохион байгуулагдсан ажиглагчид ажиллана.

Хоёр. Зоогийн газрын эд хөрөнгө.

- 2.1 Зоогийн газрын эд хөрөнгө нь үндсэн сан, эргэгтийн хөрөнгө, эзэл бүтээгдэхүүн, эмийн үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого байна.
- 2.2 Зоогийн газар нь эзэлбэр газартай байх түүнийг зохих хууль тогтоомжийн дагуу ашиглана.
- 2.3 Зоогийн газар нь өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, түүнийг ариунжуулах үүрэгтэй байх бөгөөд өөрийн мэдэлд байгаа эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, худалдах, эзэргэлийг тасралт амтлах, ашиглалтыг өөрчлөх түрээслэх зэрэг үйл ажиллагаа явуулна.
- 2.4 Зоогийн газрыг хувьчлалдаа ямар хэлбэрээр зохион байгуулахыг өөрсдөө сонгож авна.

Гурав. Зоогийн газрын удирдлага.

3.1 Зоогийн газрын үйл ажиллагааг дарга удирдаж Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд тайлагнаана.

3.2 Удирдлагын ажлыг ардчилсан, ил тод хамтач байлгахын тулд захиргааны гишүүдийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажилдуулж болно.

3.3. Захиргааны гишүүд тэдгээрийн ажиллах туршиг хамт олны санзлыг үндэслэн зоогийн газрын даргын тушаалаар батална.

3.4. БНМАУ-ын хууль тогтоомжинд бийдүүлэн зоогийн газрын дарга тушаал, заавар гаргаж биелэлтийг зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Зоогийн газрын эрх үүрэг.

4.1. Зоогийн газар нь дүрмээр батлуулж бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

4.2. Зоогийн газар нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтоомж, төр, засгийн газар, Улсанбаатар хотын хурал, Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол шийдвэрүүд болон энэхүү бүрмийг удирдлага болгоно.

4.3. Зоогийн газрын дарга нь аж ахуйн нэгжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 5-ын 14-д заасан эрх эдэлнэ.

4.4. Зоогийн газрын ажиллагсад нь өөрийн үйл ажиллагааны дагуу гарсан хууль тогтоомж, ажлын аргачлал, зааврыг бархөргчлэн биелүүлж ажиллах үүрэгтэй.

4.5. Хоол боловсруулалтын технологи ажиллагааг нарийн мөрдөх, чөлөөт жор технологид нэвтрүүлэх, ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар сургалт явуулж, үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.

4.6. Зоогийн газар нь өөрийн үйл ажиллагааг БНМАУ-ын хууль тогтоомжийн дотор гүйцэтгэнэ.

Тав. Зоогийн газрыг байгуулах, татан буулгах.

5.1. Зоогийн газрын зохион байгуулалтыг өөрчлөх, татан буулгах асуудлыг Улсанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.